

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

*Засгийн газрын үнэт цаас худалдан авах болон
хадгаламжийн хүүгийн доод хэмжээг тогтоох тухай*

2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/338 дугаартай, 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/388 дугаартай албан бичгүүдээр тус хороонд ирүүлсэн нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 150.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын үнэт цаас худалдан авах болон банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудад мөнгөн хадгаламж байршуулахад баримтлах хадгаламжийн хүүгийн доод хэмжээг тогтоох тухай санал, хүсэлтийг хэлэлцээд дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргав. Үүнд:

Нэг. Арилжааны банкуудын 2025 оны хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ 13,52 байгаа бол банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ 11,31 байна. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2026 онд арилжааны банкинд байршуулахад баримтлах хүүгийн доод хэмжээг 13,94 хувиас багагүй байхаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан санал, тооцооллыг хянаж үзээд, дэмжих нь зөв гэж тогтлоо.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.1.1-д заасны дагуу нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын үнэт цаасыг 150 тэрбум төгрөгөөр худалдан авах нь эрсдэлийн хувьд хамгийн бага гэж үнэлэгдэх боловч өгөөжийн хувьд 2025 оны арилжааны банкуудын хугацаатай хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж 13.52-оос харьцангуй доогуур байна. Гэвч 2025 онд Монголбанкны төлөөлөлтэй Мэргэжлийн хорооны гишүүдийн хийсэн уулзалтад Төв банкны үнэт цаасыг нийгмийн даатгалын сан худалдан авах боломжгүйг албан ёсоор мэдэгдсэн, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах боломж одоогоор байхгүй, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д заасан хязгаарлалтыг давах хэмжээнд хүрсэн, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын үнэт цаас худалдан авах хөрөнгийн дээд хэмжээг 300 тэрбум төгрөгөөр баталсан зэрэг нөхцөл байдалд үндэслэн Мэргэжлийн хорооны гишүүд Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн саналыг дэмжихээс өөр хувилбаргүй гэж үзэв.

Гурав. Нийгмийн даатгалын ерөнхий газар Засгийн газрын үнэт цаас худалдан авах 150 тэрбум төгрөгийг ямар төрлийн сангаас гаргах вэ?, өмнөх жилүүдэд байршуулсан нийгмийн даатгалын сангийн хөрөнгөтэй давхцал гарч, хөрвөх чадварын эрсдэл үүсэх магадлал байна уу?, 2025 онд Мэргэжлийн хорооноос гаргасан дүгнэлт зөвлөмжийн дагуу санхүүгийн хэрэгсэлд байршуулсан хөрөнгөөс хүртсэн өгөөж, үүссэн эрсдэлийн талаар мэдээлэл хорооны гишүүдэд байхгүй тул нарийвчилсан үнэлгээ хийх, дүгнэлт гаргах боломж хязгаарлагдаж байна. Цаашид Мэргэжлийн хороонд дүгнэлт, зөвлөмж гаргуулахаар хүсэлт ирүүлэхдээ холбогдох тоо мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж хавсаргах, эсвэл тухайн асуудал хариуцсан албан тушаалтныг хорооны хуралдаанд оролцуулж, танилцуулга, мэдээлэл хийж байх шаардлагатайг зөвлөмж болгохоор тогтов.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ МЭРГЭЖЛИЙН ХОРОО